

Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН “ГОЛОГДСОН ХҮҮХЭН” ТУУЖИЙН ДҮРИЙН ШИНЭЧЛЭЛ

Г.Батсуурь, МУБИС

Abstract

The main imagery in the literature is personification that is human qualities. Personification is one of the most commonly used and recognized literary devices. It refers to the practice of attaching human traits and characteristics with inanimate objects, phenomena and animals. There were three ways of describing humans in the literature, for instance, gods used to be described as the main imagery and humans as the receptors of their graces or punishment.

In the next stages of literature development, the imageries such as human-nature and human-animals used to be described. As the humane society developed, the arts and literature have developed, therefore, social and human life and their logical relations have been deeply touched in the literature. On this regard, the current trends have developed and the human qualities have become the main and central imagery in the literature.

In oral and ancient literature, heroines, good and powerful men, kings, knights and saints and holy people have become the most common imagery, while it has taken a long time up to the XX century to describe extraordinary people or nomads in the literature. Otherwise, a novel ‘An undervalued woman’ written by Damdinsuren, Ts., is the fact of describing a real extraordinary woman as the main and central imagery in the literature.

Түлхүүр үг

Уран зохиол, дүр, дүрслэгдэхүүн, дүрслэл, хүн, хүн-байгаль, хүн-амьтны завсрын шинжтэй дүрүүд, аман зохиол, эртний уран зохиол, эгэл жирийн хүний дүр

Удиртгал

Ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн” туужийг манай шинэ үеийн уран зохиолын анхны уран сайхны тууж гэж үздэг билээ. Уг туужаас өмнө буюу 1922 онд Ц.Дамбадоржийн “Толбо нуур” хэмээх нэгэн бүтээл гарсан нь манай шинэ үеийн тууж бичлэгийн түүхнээ шинэ хуудас нээсэн. Гэвч Ц.Дамбадоржийн “Толбо нуур” тууж нь түүхэн бодит үйл явдлаас сэдэвлэсэн баримтат шинжтэй зохиол юм.

Харин Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн” тууж нь уран сайхны тууж. Уг бүтээлийн талаар “Ц.Дамдинсүрэн анхны зохиолуудаа «Рашааны дусал» зэрэг Энэтхэг үлгэрээс сэдэвлэн сургаалын маягаар бичсэн бол «Гологдсон хүүхэн» туужаа хувьсгалт шинэ орны амьдралаас үндэслэн зохиожээ” (С.Лувсанвандан, Г.Жамсранжав, С.Дашдэндэв, 1968, х155 “Ц.Дамдинсүрэнгийн уран бүтээл” Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх) гэсэн нь мөнхүү туужийн уран сайхны талыг тодруулсан дүгнэлт юм. Түүнчлэн “«Гологдсон хүүхэн» тууж бол бодит байдлыг үзүүлж, хөдөлмөрчин ардын дүрийг бүтээсэн үргэлжилсэн үгийн том хэлбэрийн нэлээд дорвитой зохиол юм”

(С.Лувсанвандан, Г.Жамсранжав, С.Дашдэндэв, 1968, х159) гэсэн буй. Мөн “«Хувьсгалын соёлыг яруугаар найруулж, харанхуй мунхгийн сэжиг, балар хоосон үзэл хийгээд дарлах дарлагдах суртал ба байдал лугаа тэмцээ» гэсэн үндсэн зорилгоор бичсэн “Гологдсон хүүхэн” хэмээх туужид ядуу зүдүү амьдралтай эгэл олон шинэ гэрэл гэгээт замд давшиж байгаа төвөг ээдрээтэй замыг харуулсан юм” (Д.Цэдэв, 2008, “Ц.Дамдинсүрэнгийн зохиол бүтээлүүд” Эмхэтгэж редакторласан Л.Хүрэлбаатар Академич Цэндийн Дамдинсүрэн. дурсгалын түүвэр. УБ. 148-149) гэжээ. Оросын монголч эрдэмтэн Л.К.Герасимович “«Гологдсон хүүхэн» тууж эгэл жирийн хүн ардыг хувьсгалт ухамсраар хүмүүжүүлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн юм. Ц.Дамдинсүрэнгийн ертөнцийг үзэх хувьсгалт үзэл түүнээс хувьсгалт тэмцлийн практиктай нягт холбоотой байсан явдал нь уг туужийн үзэл санааны үндсэн чиглэлийг тодорхойлж байна” (Л.К.Герасимович, “Литература Монгольской Народной Республики (1921-1964 годов)” МЛУ, 1965, х92) гэжээ.

“Гологдсон хүүхэн” тууж 1929 оны 5-р сарын 1-нд (С.Лувсанвандан, Д.Цэдэв, Ц.Мөнх,

* batsuuri@msue.edu.mn

Ч.Билигсайхан, Д.Дашдорж, “Тэмдэглэлт үйл явдлын жагсаалт” Монголын орчин үеийн уран зохиолын түүх. УБ. 1985, х431) анх хэвлэгдсэн. Энэ тухайгаа зохиолч Ц.Дамдинсүрэн “1929 оны нэгдүгээр сарын 9-нд уран зохиолчдын бүлгэмийг анх байгуулахад элсэн орж тэргүүлэгчээр нь сонгогдсон ба мөн бүлгэмийн даалгавраар “Гологдсон хүүхэн” гэдэг анхны туужаа бичиж хэвлүүлсэн” (Д.Цэдэв “Өөрийн намтар” Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. 1998, х20) гэж бичсэн байдаг. 1929 онд буюу зохиолчдын бүлгэм байгуулагдаж байх үеийн монголын уран зохиолын төлөв байдлыг үзвэл ардын аман зохиолын уламжлал, бичгийн зохиолын төрөл зүйлүүд зонхилж байсан бөгөөд шинэ үеийн уран зохиол эхлэл төдий байсан билээ. Тодруулбал аман зохиолын төрөл зүйлүүд болох үлгэр, домог, хууч яриа, баатарлаг туульс, ардын дуу, оньсого таавар, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав зэрэг, бичгийн зохиолын хувьд сургаалын зохиол (Оюунтүлхүүр, Чингисийн билэг, Авах гээхийн дөрвөн мөрт гэх мэт), тууж (Гэсэрийн тууж, Шар тууж, Эндүүрэл хааны тууж, Нарангэрэлийн тууж гэх мэт), намтар зохиол (Нэйж тойны намтар зэрэг), Энэтхэг, Төвдийн уламжлал бүхий бичгийн зохиолуудын (монгол Ганжуур, Данжуур, Үлгэрийн далай, Таван сургамж, Эрдэнийн сан Субашид гэх мэт) уламжлал зонхилж байлаа. Өөрөөр хэлбэл XX зууны 1930-аад оны үе хүртэл манай уран зохиол дундад зууны үеийн уран зохиолын чиг хандлагаас ангижраагүй байсан юм.

Ардын аман зохиолын төрөл зүйлүүд болох үлгэр, домог, туульс зэрэг нь дүрслэлийн хувьд сайн муу, сайхан муухай гэсэн хоёр туйлд хуваагдсан шинжтэй байдаг бөгөөд уран зохиолын дүрслэгдэхүүний талаас үзвэл уран зохиолын төв байрыг хүн эзлэхээс өмнөх үед хамаарах юм. Дараагийн үед уран зохиолын дүрслэлийн төв үрүү хүн орж ирсэн хэдий ч эртний бичгийн зохиолууд болон дундад зууны үеийн бичгийн зохиолуудад хэн нэгэн хүчирхэг баатар эр, эзэн хаан эсвэл ер бишийн хүчин чадал, ид шидтэй, хувилгаан чанартай дүрүүд дүрслэгдэж ирсэн буй.

Нийт уран зохиолын түүхийг үзвээс эгэл жирийн хүний дүр уран зохиолын төв байрыг эзлэх хүртэл чамгүй урт хугацааг туулсан бөгөөд манай уран зохиолын хувьд XX зууны 30-аад он хүртэл эгэл жирийн хүний дүр уран зохиолд жинхэнэ утгаараа дүрслэгдээгүй байсан гэж үзэж болох юм. Тодруулбаас ардын үлгэрт шагаагаар нь шар эсгий цувсан, борвиор нь бор эсгий цувсан, хамуутай хар даагатай нусгай бор хүү дүрслэгдэх агаад гэнэтийн тохиолдлоор мөнөөх өнчин

хүү хосгүй хүч чадал, төгс төгөлдөр бүрдмэл баатар эр болон хувирч арван таван толгойтой атгаалжин хар мангасыг даран ард олноо амар жимэр жаргуулж буйгаар өгүүлдэг.

Бичгийн уран зохиолд уг уламжлал хадгалагдаж ирсэн агаад хэн нэгэн баатар сайн эр, хосгүй ухаан билэг төгс хааны тухай өгүүлэмж зонхилж байв. Тухайлбал их эзэн Чингис хааны дүрийг туульсын баатрын байдлаар дүрсэлж ирсэн нь нэн түгээмэл. Үүнийг нь “Аргасун Хорчийн домог” зохиолын бүх хүний учрыг тайлж эс чадах шүлгийн далд санааг Чингис хаан төвөггүй тайлан хэлж буйгаас, “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний цэцэлсэн шаштир” зохиолын Чингис хаан бүхний учрыг ялган хэлж буйгаас, “Чингисийн эр хоёр загалын тууж” зохиолын Чингис хаан хэрхэн мэргэн зүүдэлж байгаа зэргээс тус тус үзэж болно. Уг уламжлал нь 1930-аад оны үеийг хүртэл хадгалагдсан бололтой.

Манай шинэ уран зохиолын анхны тууж хэмээн үздэг Ц.Дамбадоржийн 1922 онд бичсэн “Толбо нуур” зохиолын гол дүрүүд нь Хасбаатар, Байкалов, Абмад (Дамбадорж) нарын зэрэг хувьсгалч дайчин хүмүүс байдаг. Үйл явдал нь Ховдын хязгаар Саруул гүний хүрэнээ өрнөх агаад цагаантанд бүслэгдэн 42 хоног идэх хоолгүй зовж байгаад хэрхэн золоор амь гарсан тухай өгүүлнэ. Уг туужийн дүрүүд нь туульсын уламжлалын элементтэй байдаг бол үйл явдал нь туурьлаг шинжтэй юм. Туурь гэдэг нь амьдралд тэр бүр тохиолддоггүй ер бишийн сонин үйл явдалд шүтсэн онцлогтой байдгийг “... Өгүүлэгтэй харьцуулбал хурц зөрчил, хураангуй өгүүлэмж, үйл явдлын эргэлт бүхий уран /санаанд оромгүй эсрэг байдалд/ тайллаараа ялгардаг богино хэмжээний хүүрнэл зохиолыг туурь гэнэ” (Д.Галбаатар, “Туурь” Уран зохиолын нэвтэрхий толь. УБ. 2012, х362) гэсэн тодорхойлолтоос харж болно. Уг төрөл зүйл нь уран зохиолын түүхийн нэлээд эрт үед ихээхэн дэлгэрч байсан нь дундад зууны сүүл сэргэн мандалтын эхэн үеийн Италийн зохиолч Ж.Боккачогийн арван өдрийн туурь буюу “Декамерон” хэмээх алдарт бүтээлийн жишээнээс харагддаг. Ингэхээр Ц.Дамбадоржийн “Толбо нуур” тууж нь түүхэн бодит хүмүүс, бодит үйл явдлыг дүрсэлсэн болохын хувьд баримтат зохиол, дүрслэл өгүүлэмжийн хувьд туульсын болон туурийн уламжлалтай өөрөөр хэлбэл жирийн хүмүүсийн дүрээс илүүтэй удирдагч нар дарга нарын дүрүүд голлон дүрслэгдсэн дундад зууны уламжлал нь давамгайлсан шинжтэй зохиол юм.

Тэгвэл уг бүтээлээс 7 жилийн дараа бичигдсэн Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон

хүүхэн” (Д.Цэдэв, Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. 1998, х 6-38) туужийн гол дүрүүд болох Цэрэн, Долингор, Мядаг, баян Болд, Дэжид, Ловон лам, хоньчин хүү Дамдин, Дамдингийн ээж, хүү Данзан, Лувсан гэлэн, түшмэл На, Хуяг тайж, Цэрэнгийн нөхөр “Хөсрий илүүр” хочит Буян зэрэг нь цөм эгэл жирийн хүмүүсийн дүр юм. Цэрэн хүүхний намтар болох уг тууж нь өгүүлэмж талдаа ардын үлгэрийн уламжлалтай. Үлгэрийн гол баатар эхэн үедээ ихээхэн зовлон бэрхийг туулж аз жаргалд хүрдгийн адил Цэрэн хүүхэн ч төрмөгцөө гологдон, ад үзэгдэж, нас биед хүрмэгцээ Хөсрий илүүр хочит Буянд богтлогдон хэдэн жил зарагдан дарлагдаж, эцэст нь оргон зайлж бичиг үсэгт боловсрон сайн цагийн буянаар аавтайгаа уулзан аз жаргалд хүрч буй нь үлгэрийн уламжлал. Хэдий өгүүлэмж нь ардын үлгэрийн уламжлалтай боловч дүрслэл нь бодит шинж чанартай агаад эгэл жирийн хүмүүс дүрслэгдсэн болохын хувьд манай шинэ үеийн реалист уран зохиолын үндэс суурийг тавьсан бүтээл юм.

Зохиолын гол дүр Цэрэнг “...Жич мэргэн зурхайчаас даруй үхнэ гээд нэг ч амьтан хэрэглэхгүй байсан Цэрэн, төрснөөс хойш эцэг эхээ нэг ч айлгасангүй найм есөн нас хүрчээ. Энэ охиныг харин Болдын эхнэр гар хөлийн үзүүрт зарах сайн зарц болгон, зун бол хурга тугал хариулгаж, халуун наранд хатаана...” (Д.Цэдэв, Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. 1998, х15) гэх зэргээр бага насыг нь дүрсэлсэн байгаа бол нас биед хүрсэн үеийг нь “...1923 он болоход Мядагийн хүүхэн Цэрэн 18 нас хүрч ухаан сэргэлэн, өнгө зүс сайтай, бичиг үсэг муухан төсөөлөх болсон ажээ...” (Д.Цэдэв, Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. 1998, х15) хэмээсэн байгаа нь цөм жирийн хүний дүр дүрслэл бөгөөд ямар нэгэн хэтрүүлэггүй тухайн үеийн нийгмийн жирийн нэгэн гишүүний дүр болсон байна.

Мөн Долингорыг “...Энэ хүн бол гучаад настай, махлаг хөх царайтай, толгойд хир болсон хөх цууямбуу зангиджээ...” гэх буюу “...50-аад нас хүртэл насан туршаар зовсон Долоодойн хоёрдугаар баяр нь энэ билээ. Долоодой Мядагийг мэнд сайн сууж байгаа гэхийг сонсож, эдүгээ хүүхэнтэйгээ уулзасанаар үл барам, Мядагтай бас уулзах болно гэж...” (Д.Цэдэв, Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. 1998, х15) гэх мэтээр дүрсэлсэн буй.

Зохиолын эсрэг дүр болох баян Болдыг аман зохиолын эсрэг дүрийг дүрсэлдэг шиг хэтэрхий муучлан үзүүлээгүй байгаа нь сонирхолтой. Тухайлбал “...Баян Болдын нас нь дөчөөд, толгой нь халзан, гэдэс нь бүдүүн, сахал нь битүү, нүд нь улбар, зан нь төв боловч заль

нь их бололтой. Чисчүүнээс дээш хувцас үл эдлэх бөгөөд сайн хувцасгүй...” (Д.Цэдэв, “Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол”, УБ. 1998, х8) гэсэн нь анхаарал татна. Манай уран зохиолд сүүлдээ баян хүнийг ихээхэн гоё ганган, юу ч хийдэггүй залхуу, идэмхий уумхай байдлаар үзүүлэх хандлага нэлээд дэлгэрсэн буй. Харин уг дүрийн уламжлалыг хөгжүүлсэн дүр бол Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы баян Итгэлтийн дүр. Зохиолч Ц.Дамдинсүрэн Болдын дүрийг хэдий баян боловч өмсөж эдлэхдээ гар татуу, зальтай байдлаар үзүүлсэн нь амьдралд ойрхон болсон төдийгүй дүрийг хэт зохиомол байдлаар дүрсэлдэг дундад зууны үеийн дүрслэлийн уламжлалаас холдуулж шинэ үеийн монголын уран зохиолын дүрийн санд нэгэн шинэ дүр бий болгожээ. Түүнчлэн зохиолын цаг хугацааг ч ихэд тодорхой байдлаар “...1918 оны цагаан сар болж...” (Д.Цэдэв, “Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол”, УБ. 1998, х19) гэх буюу “...1923 он болоход...” гэх зэргээр бичсэн байгаа нь зохиолын үйл явдал, амьдрал байдлыг ихээхэн бодитой, үнэмшилтэй болгосон байна. Бодитчилох хандлагатай ч бас уран сайхны дүр дүрслэлийг орхигдуулаагүй нь “...Байдалд зохист намар цаг, сэтгэлд зохист яруу газар, Бэлэн далай хэмээх зөөлөн говь нутагт...” (Д.Цэдэв, “Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол”, УБ. 1998, х32) гэх зэрэг байгалийн зураглал, баян Болдыг болон түүний эхнэрийг “...Түүний эхнэр Дэжид нас 40 хэр, ааш зан хурдан, үг хэл ширүүн, санаа сэтгэл сайнгүй, эд юманд харамч билээ...” (Д.Цэдэв, “Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол”, УБ. 1998, х6) гэх мэтээр дүрсэлсэн хөрөг дүрүүдээс болон бусад олон уран сайхны дүрслэлээс нь харж болно.

Өдгөөгийн уран зохиолын дүрслэгдэхүүний төв байранд хүн байдаг. Хүн уран зохиолын дүрслэгдэхүүний төв байрыг эзлэх хүртлээ гурван замыг туулсан агаад эртний туульсын зохиолуудад бурхан тэнгэрүүд төв байранд дүрслэгдэх ба хүн тэрхүү бурхан тэнгэрийн хайр хишгийг хүртэгч эсвэл гэсгээл цээрлэлийг хүлээгч маягаар дүрслэгдэж ирсэн буй. Хөгжлийн дараагийн шатанд хүн-байгаль, хүн-амьтны завсрын шинжтэй дүрүүд уран зохиолд дүрслэгдэж ирсэн бөгөөд хүний нийгэм хөгжихийн хэрээр урлаг уран зохиолын хөгжил улам бүр нарийсаж нийгмийн амьдрал, хүний аж төрөл, тэдгээрийн учир зүй, холбоо хамаарал уруу гүнзгийрэн орж эдүгээгийн төлөв хандлага бий болж хүн уран зохиолын төв байрыг эзэлсэн билээ. Дундад зууны үеийн уран зохиолд ихэвчлэн баатар сайн эрс, хүчирхэг хаад ноёд, хувилгаан лам хутагтуудын дүр зонхилж ирсэн

ба эгэл жирийн хүн, манай уран зохиолын хувьд гэвэл жирийн малчин ардын дүр уран зохиолын төв байранд дүрслэгдэх хүртлээ нэлээд урт удаан хугацааг туулж ХХ зууны 30-аад оныг хүрчээ.

Тийн явсаар эгэл жирийн хүн уран зохиолын төв байранд жинхэнэ утгаараа дүрслэгдсэн нь Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн” туужийн баримт болж байна. Хэдийгээр “Гологдсон хүүхэн” тууж нь зарим алдаа дутагдалтай 1975 онд зохиолчийн өөрийнх нь дүгнэсэнчлэн “олон дутагдалтай анхны оролдлого зохиол” (Э.Пүрэвжав, “Үргэлжилсэн үгийн зохиол” Их эрдэмтэн академич Цэндийн Дамдинсүрэн. УБ. 2008, х67) боловч дундад зууны үеийн уран зохиолын уламжлал болох туульслаг дүрслэлийн уламжлалыг даван гарч эгэл жирийн ардын дүрийг уран зохиолын төв байранд оруулж ирснээрээ цоо шинэ бүтээл болж чадсан билээ. Энэ нь уг туужийн хувьсгалт шинэ үзэл санааг илэрхийлсэн, хуучин нийгмийн гишүүдийг шүүмжилсэн, анхны уран сайхны тууж гэдгээс илүү нийт монголын уран зохиолын түүхийг алхам урагшлуулсан дэлхий нийтийн уран зохиолын чиг хандлагад өөрийн үндэстний уран зохиолыг нийцүүлсэн томоохон шинэчлэл хийсэн бүтээл гэж дүгнэх боломжтой юм.

Ашигласан материал

- Батсуур, Г. (2010) Удиртгал. Улаанбаатар
 Батсуурь, Г. (2012). Ц.Дамдинсүрэнгийн яруу найргийн аман зохиолын уламжлал. Улаанбаатар
 Гаадамба.Ш. (1989) Утга зохиолын онолын үндэс. Улаанбаатар
 Галбаатар.Д. (2009) Монголын уран зохиолын онол түүхийн зангилаа асуудлууд. Улаанбаатар
 Галбаатар.Д. (2012) Уран зохиолын нэвтэрхий толь. Улаанбаатар
 Герасимович.Л.Г. (1965) Литература Монгольской Народной Республики (1921-1964 годов) МЛУ
 Лувсанвандан.С. Жамсранжав.Г. Дашдэндэв.С. (1968) Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх. Улаанбаатар
 Хүрэлбаатар.Л. (2008) Академич Цэндийн Дамдинсүрэн. дурсгалын түүвэр. Улаанбаатар
 Цэдэв.Д. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. 1-р дэвтэр. Улаанбаатар
 Цэдэв.Д. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. 2-р дэвтэр. Улаанбаатар
 Лувсанвандан.С. Цэдэв.Д. Мөнх.Ц.

Билигсайхан.Ч. Дашдорж.Д. (1985) Монголын орчин үеийн уран зохиолын түүх. Улаанбаатар

Пүрэвжав.Э. (2008) Их эрдэмтэн академич Цэндийн Дамдинсүрэн. Улаанбаатар

Энхбаяр.С. (2011) Утга зохиолын онол. Улаанбаатар